



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Мандах Их сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт боллоо

Мандах Их сургуулийн 31 дах удаагийн буюу 2022-2023 оны хичээлийн жилийн нээлт 2022 оны 08 сарын 29-ны өдөр ёслол төгөлдөр болж өндөрлөлөө.

Нээлтийн арга хэмжээг Мандах Их Сургуулийн захирал профессор Г.Нанжид нээж, нийт эрдэмтэн багш, оюутан суралцагчид, ажилчиддаа хичээлийн жилийн баяр хүргэж, сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүслээ. Уламжлал ёсоор 2022-2023 оны хичээлийн жилд ЭЕШ-ийн өндөр оноотой элссэн оюутнуудад 20-50%-ийн Хөнгөлттэй суралцах эрхийн бичгийг гардууллаа.



Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залав

Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигийн дагуу, БШУЯ-ны сайдын 2022 оны 08 дугаар сарын 17-ны А/289 дүгээр тушаалыг үндэслэн Эзэн Богд Чингис хааны эш хөргийг бүх шатны сургалтын байгууллагад дээдлэн залах, Их хааны үйл хэргийг алдаршуулах арга хэмжээг Мандах Их сургууль 2022-2023 оны хичээлийн жилийн эхний өдөр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залж, Их хааны үйл хэргийг алдаршуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Энэхүү түүхэн арга хэмжээнд Мандах Их сургуулийн захирал, профессор Г.Нанжид, сургуулийн удирдлагууд, багш, ажилтан, оюутнууд оролцож, тус сургуулийн багш, түүхч, доктор О.Баттуяа Эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх, эв эеийг бататгах талаар мэдээлэл хийлээ.

Мөн СШУТ-ийн багш М.Ганхөлөг Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг сургуулийн удирдлагууд, багш, ажилтан, оюутнуудад уншиж сонордууллаа.

Арга хэмжээнд хүндэтгэл үзүүлж Мандах Их сургуулийн Банкны менежментийн 3-р ангийн оюутан Ө.Баярцэцэг “Чингисийн аялгуу” хэмээх морин хуурын аялгуугаар мэндчилгээ дэвшүүлээ.



Мандах их сургуулийн захирал, Профессор Г.Нанжид Япон улсын Тохоку их сургуулийн Оюутан солилцооны хөтөлбөрт суралцах оюутнуудыг хүлээн авч уулзлаа

Мандах их сургууль болон Япон улсын Тохоку их сургуулийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тус их сургуулиас 2022 оны намрын семестрын Оюутан солилцооны хөтөлбөрийг зарласан бөгөөд энэхүү хөтөлбөрт Мандах их сургуулийн Инженер-эдийн засгийн 4-р дамжааны оюутан Б. Ичинхорлоо, Нягтлан бодох бүртгэл-Англи хэлний 3-р дамжааны оюутан Л. Саруул нар оролцохоор сонгогдсон байна.

Солилцооны 2 оюутан маргааш Япон улсыг зорих гэж байгаатай холбогдуулан Мандах их сургуулийн захирал Г.Нанжид өнөөдөр хүлээн авч уулзав. Уулзалтанд Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал Ч. Төрбадрах, Сургалтын албаны дарга С. Энхзаяа, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан З. Булганаа нар оролцлоо.

Захирал Г. Нанжид Тохоку их сургуулийн Оюутан солилцооны хөтөлбөрийн болзлыг хангаж, үе тэнгийн оюутнуудаа төлөөлөн оролцох болсонд баяр хүргэж, тэдэнд хандаж, үнэтэй зөвлөгөө өглөө. Тэрээр Японы их дээд сургуулиудын сургалтын онцлог, оюутан залуусын хандлага, тэдний суралцах арга барил техник, манай сургуулийн сургалтын арга зүйгээс юугаараа давуу, мөн юугаараа сул байгааг харьцуулж үзэх, дэвшилтэт техник технологийг сургалтандаа хэрхэн ашиглаж байгаа болон бусад орны гадаад оюутнуудтай танилцах, тэдэнтэй найзалж нөхөрлөж, өөрийн сургуулийн талаар танилцуулж, туршлагаа хуваалцах, түүнчлэн хөтөлбөрөөс олж авсан мэдлэгээ буцаж ирээд өөрийн сургуулийн оюутнууддаа хуваалцахыг зөвлөлөө.

Уулзалтын төгсгөлд 2 оюутанд Мандах их сургуулийн лого бүхий дурсгалын зүйлс гардуулж, солилцооны хөтөлбөрт амжилттай суралцаж, эх орондоо эргэн ирэхийг ерөөлөө.



Багш нарын өдрийг тэмдэглэлээ

Дэлхийн багш нарын 28 дахь, Монголын багш нарын 56 дахь өдрийг тохиолдуулан Мандах их сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилд ажил, хөдөлмөрөөрөө шалгарсан, шилдэг багш нараа шагнаж урамшууллаа.

Үүнд: оны “Шилдэг багш”-аар Гадаад хэлний тэнхимийн дэд профессор, доктор С.Ганцэцэг, “Шилдэг залуу багш”-аар Эдийн засаг бизнесийн тэнхимийн багш П.Насанжаргал нар шалгарч шагнууллаа. Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны Жуух бичгээр Гадаад хэлний тэнхимийн багш Т.Оюун-Эрдэнэ, Сангийн яамны Жуух бичгээр Бүртгэл шинжилгээний тэнхимийн багш Г.Золбоо, Э.Энх-Амгалан нар тус тус шагнагдлаа. Шагналыг сургуулийн Захирал профессор Г.Нанжид, Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал доктор, профессор Л.Энх-Амгалан, Сургалт эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор Ч.Төрбадрах, Санхүү эрхэлсэн дэд захирал С.Энхтүвшин нар гардуулж цаашдын ажил, хөдөлмөрт нь өндөр амжилт хүслээ.



Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандартын магадлах аудитыг амжилттай хийлгэлээ

Мандах их сургууль Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг нэвтрүүлсэн Монголын анхны дээд боловсролын байгууллага бөгөөд Энэтхэгийн “IRCLASS” чанарын баталгаажуулалтын байгууллагаас жил бүр тус стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэх магадлах аудитыг хийдэг. Энэ жилийн магадлах аудитыг 2022 оны 10 –р сарын 12-13-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Аудитын дүгнэлтээр Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг Мандах их сургууль амжилттай хэрэгжүүлж байна гэсэн үнэлгээг өглөө.

Магадлах аудитад бэлтгэж, тайлан хамгаалах ажлын хэсгийн багийн ахлагчаар Сургалт эрхэлсэн дэд захирал Ч.Төрбадрах, багийн гишүүнээр Захирлын ажлын албаны дарга С.Энхтуяа, Чанарын Үнэлгээний ажилтан Д.Доломжав, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан З.Булганаа нар ажиллалаа.




Мандах их сургуулийн оюутнууд Олон улсын оюутнуудын соёлын солилцооны онлайн арга хэмжээнд амжилттай оролцлоо

Мандах их сургуультай хамтран ажилладаг Индонезийн Стеком их сургуулиас зохион байгуулсан олон улсын оюутнуудын соёлын солилцооны 2 өдрийн хөтөлбөрт Мандах их сургуулийн оюутнууд амжилттай оролцлоо. Тус арга хэмжээнд Индонези, Беларус, Этиоп, Уганда, Өмнөд Африк, Малайз, Монгол, Казакстан, Украин, Узбекистан, Вьетнам, Бруней зэрэг нийт 12 орны их дээд сургуулийн оюутнууд оролцож, өөрийн орны соёл урлаг, үндэсний хоол, үндэсний хувцас, кино урлаг, дуу бүжиг, зан заншлын талаар зурагт болон видео танилцуулга хийлээ. Оролцогч оюутнууд орон орны соёлын өвөрмөц онцлог, байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний хоол, үндэсний хувцас, урлаг соёлын талаар мэдлэг мэдээлэл авч байгаадаа талархаж байгаагийн зэрэгцээ тухайн улс оронд очиж, үзэх хүсэл төрж буйгаа илэрхийлж байв.

Мандах их сургуулийн Бизнесийн удирдлагын 2-р дамжааны оюутан Х.Түвшинтулга “Монголын кино урлаг, дуу хөгжим” сэдвээр танилцуулга бэлтгэж, англи хэл дээр тайлбарлаж оролцлоо. Түүний бэлтгэсэн танилцуулгыг бусад орны оюутнууд ихэд сонирхон, олон олон асуултыг тавьж байв. Ялангуяа уртын дуу, морин хуурын аялгууг сонсгож, тэдгээрийн түүхийг ярьж өгсөн нь оролцогчдын сонирхлыг ихээр татсан юм. Энэхүү соёлын арга хэмжээнд оролцсоноор манай оюутнууд бусад орны үе тэнгийн оюутнуудтай англи хэлээр чөлөөтэй харилцаж, харилцан туршлагаа хуваалцах сайхан боломжийг олж авсан билээ.

Монголын соёл урлагийн талаар танилцуулга бэлтгэж, гадаадын улс орны оюутнуудад танилцуулсан оюутан Х.Түвшинтулгадаа баяр хүргье!



Мандах Их Сургууль болон Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, Технологийн их сургуультай хэрэгжүүлж буй хос диплом олгох хөтөлбөрийн 4-дэх удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа боллоо

Мандах Их Сургууль болон Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, Технологийн их сургуультай 2016 оноос эхлэн хэрэгжүүлж буй хос диплом олгох хөтөлбөрийн 4-дэх удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа 2022 оны 10 дугаар сарын 10-ний өдөр боллоо.

Энэ жил уг хөтөлбөрт хамрагдсан нягтлан бодох бүртгэл, санхүү, инженер эдийн загийн бакалаврын болон магистрантууд хамрагдаж хос дипломоо гардан авлаа. Тус хөтөлбөрийн онцлог нь мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг англи хэл дээр судалдаг бөгөөд цаашид төгсөгчид ахисан түвшинд гадаад, дотоодын их, дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах, мэргэжлийн хувьд өөрийгөө хөгжүүлэх чухал ач холбогдолтой юм.

Төгсөлтийн ёслолын ажиллагааг Мандах Их Сургуулийн захирал, профессор Г.Нанжид нээж, хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд болон тухайн хөтөлбөрт хичээл заасан багш нарт баяр хүргэн, уг хөтөлбөрийн төгсөгчдөд олон давуу тал, боломж олгож байгааг онцлон тэмдэглэж цаашдын ажил, хөдөлмөрт нь амжилт хүслээ.



Үйл явдлууд

Мандах Их Сургуулийн ЭЗБТ-ийн эрхлэгч Б. Сайнжаргал Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуулийн докторын зэргийг амжилттай хамгааллаа.

Мандах Их Сургуулийн ЭЗБТ-ийн эрхлэгч Б. Сайнжаргал Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуулийн докторын зэргийг амжилттай хамгааллаа.

Мандах Их Сургуулийн ЭЗБТ-ийн эрхлэгч Б.Сайнжаргал 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр МУИС-ийн Бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D) зэргийг “Хэрэглэгчийн зах зээлийг сэтгэл зүйн үзүүлэлтээр сегментчлэх арга зүйн асуудал” сэдвээр амжилттай хамгааллаа. Доктор (Ph.D) Б.Сайнжаргал багшдаа эрдмийн их ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.



Үйл явдлууд

Тэрбум мод тарих төслийн хүрээнд SGS ХХК болон БОАЖЯ-аас зохион байгуулсан мод тарих үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн хамт олон нийгмийн хариуцлагынхаа хүрээнд идэвхитэй оролцлоо.

2022 оны 10 сарын 22-ны өдөр “Богд уулын Энхтайваны аманд” Мандах Их Сургуулийн багш, ажилтан, оюутнууд болон SGS компанийн хамт олон 5 настай шинэс 2800 ширхэг, навчит мод 1200 ширхэг нийт 4000 мод тарьж суулгалаа. Үйл ажиллагаанд Байгаль Орчин Аялал Жуулчлалын яамны сайд Б.Бат-Эрдэнэ, Мандах Их Сургуулийн захирал, профессор Г.Нанжид, SGS компанийн Ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал А.Далангурван нар оролцож үйл ажиллагааг нээж үг хэллээ.

Хүндэт зочид болон гүйцэтгэх удирдлагууд мод тарьж суулгасан бөгөөд Монголын мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн холбооны удирдлага мод тарих арга зүйгээр хангаж ажиллалаа.



Донорын өдөрлөг боллоо

Мандах Их Сургууль нь Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “Цусаа өгч эрдэнэт хүний амь аваръя” уриан дор Донорын өдөрлөгийг жил бүр зохион байгуулдаг.

Энэ жилийн өдөрлөгийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж тус сургуулийн 44 багш, ажилтан, оюутан залуус 15,4 литр цус хандивлаж, 150 хүнд амьдрал бэлэглэх боломж бүрдлээ.

Нэг хүний бэлэглэсэн цус бүрийг 3 хуваан цус, цусан бүтээгдэхүүн болгон эрдэнэт хүний амь насыг аврах буянт үйлсийг бүтээдэг байна.



“EduTech Asia 2022” олон улсын чуулга, уулзалтад Мандах ИС-ийн төлөөлөл оролцлоо.

Сингапур улсад 11-р сарын 8-10-ны хооронд зохион байгуулагдаж буй Боловсрол-Технологи 2022 (EduTech Asia 2022) олон улсын боловсролын чуулга уулзалтад Мандах ИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор Ч.Төрбадрах, Мэдээлэл, технологийн сургуулийн захирал Ө.Ганзориг нар оролцлоо. Уг чуулга уулзалтад оролцсоноор боловсролын байгууллагын ухаалаг технологид суурилсан ирээдүйн чиг хандлага, дэвшилтэт технологийг сургалтдаа нэвтрүүлж сайжруулах, гадаадын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, санал солилцох зэрэг чухал ач холбогдолтой юм. Тус чуулга, уулзалтад дэлхийн олон орны нийт 7000 гаруй төлөөлөл оролцсон ба дэлхийд технологиор тэргүүлэгч Microsoft, Google, Intel, Adobe, Coursera, Dell, Open LMS, Academia, Edpuzzle, Anthology зэрэг компаниуд, боловсролын салбарт тэргүүлэгч сургуулиудын удирдлага, багш, сурган хүмүүжүүлэгч нарын төлөөлөл 300 гаруй илтгэгч нар боловсролын салбар дахь дэвшилтэт технологи, түүний сургалтын хэрэглээ, боловсролын бүх шатны байгууллагын тулгамдаж буй асуудал болон цаашид хэрэгжүүлэх бодлогоо танилцуулж, харилцан санал солилцсон. Мандах Их Сургуулийн сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг Google Workspace, Moodle системүүд нь тус үзэсгэлэнд оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж, сурталчилж байгаа нь бидэнд их таатай, дотно санагдлаа. Мандах ИС-ийн төлөөлөл нь энэхүү чуулга уулзалтын дараа Сингапурын Үндэсний Их Сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа. Сургуулийн төв номын сангийн үйл ажиллагаатай тусгайлан танилцсан. Манай сургуулийн төлөөллийг халуун дотноор хүлээн авч, номын сангийн давхар бүрээр үйл ажиллагааг дэлгэрэнгүй танилцуулж өглөө. Тус номын сан нь 6 давхар орчин үеийн шийдэл бүхий ухаалаг системтэй ба уншигчдын тав тухтай байдлыг бүрэн хангасан, түүнчлэн багш, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны хурал, багийн хурал, семинар зохион байгуулах танхимуудтай юм.



“JOB FAIR-2022” нээлттэй ажлын байрны өдөрлөг зохион байгуулагдлаа

Мандах Их Сургууль ажил олгогчдын хүний нөөцийг бүрдүүлэхэд туслах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутнуудыг танилцах болон мэргэжлийн дадлага хийлгэхэд зуучлах, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой жил бүрийн 12 дугаар сард ажлын байрны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жилийн ажлын байрны нээлттэй өдөрлөг 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж Номин Холдинг ХХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг ТББ, Мүүрь Аудит, Миний Дэлгүүр ХХК, Грант Торнтон аудит ХХК, Эрин интернэшнл ХХК, Capitron Bank, Central express CVS, Isc ХХК, ЧПМ ХХК, Асаяке ХХК, Юнифайд Файнаншл Солюшнс Аудит ХХК, "АОДЭ" Групп, Бигүүр ХХК, Монре даатгал зэрэг нийт 18 байгууллага оролцлоо. Тус өдөрлөгт үйлдвэрлэлийн дадлага хийх, төгсөөд ажиллах зорилготой Мандах Их Сургуулийн 3, 4 дүгээр дамжааны оюутнууд идэвхитэй оролцож нээлттэй ажлын байрны ажил горилогчийн анкетыг нийт 301 оюутан бөглөсөн байна. Өдөрлөгийн үеэр оюутан залуусын мэдлэг, ажиллах ур чадвар, хандлагын талаар ажил олгогчтой уулзалт, хэлэлцүүлгийг мөн зохион байгуулсан нь сургалтын хөтөлбөрийг сайжруулах чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Мандах их сургууль 2022 оны “Шилдэг түнш байгууллага”-аа тодрууллаа

Мандах их сургууль нь төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуй нэгж компани болон 80 гаруй дотоодын байгууллагатай сургалт, семинар улсын хэмжээний олимпиад, уралдаан, тэмцээн, эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулах, оюутны тэтгэлэгт хөтөлбөр зарлах, оюутны танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгохтой холбоотой санал санаачлагыг хэлэлцэх чиглэлээр хамтран ажилладаг.

Энэ жилээс эхлэн Мандах их сургуультай тогтвортой, найдвартай хамтран ажиллаж, сургалт судалгааны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмрээ оруулж буй хамтрагч байгууллагыг оны “Шилдэг түнш байгууллага”-аар шалгаруулж, урамшуулах ажлыг уламжлал болгон зохион байгуулахаар боллоо.

2022 оны “Шилдэг түнш байгууллага”-ын эзнээр Номин Холдинг ХХК шалгарч, шагналыг Мандах их сургуулийн захирал, профессор Г.Нанжид тус сургуулийн Магистрын хөтөлбөрийн төгсөлтийн баярын үеэр Номин Холдинг ХХК-ний Хүний нөөцийн бодлогын газрын захирал Д.Отгоннямд гардууллаа. Мөн Мандах их сургууль болон Номин Холдинг ХХК-ний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хичээл зүтгэл, хүчин чармайлт гарган амжилттай ажилласан хувь нэмрийг үнэлж, Номин Холдинг ХХК-ний Бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын ахлах менежер Э.Сүрэнхорлоод “Талархал”, мөнгөн урамшуулал олгов. Шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Номин Холдинг ХХК-ний Хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Оюунболд оролцлоо.



Үйл явдлууд

Магистрын хөтөлбөрийн төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн магистрын хөтөлбөрийн 21 дэх удаагийн төгсөлтийн үйл ажиллагаа 2022 оны 12 сарын 26-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг нээж мандах ИС-ийн захирал профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд болон тухайн хөтөлбөрт хичээл заасан багш нарт баяр хүргэн, уг хөтөлбөрийн төгсөгчдөд олон давуу тал, боломж олгож байгааг онцлон тэмдэглэж цаашдын ажил, хөдөлмөрт нь амжилт хүслээ. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө Энэ удаагийн төгсөлтөөр Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Бизнесийн удирдлага хөтөлбөрөөр нийт 45 магистрант төгслөө. Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааны үеэр дипломын ажил бичиж төгссөн нийт 6 оюутан болон 3.7-оос дээш голч дүнтэй суралцсан 11 төгсөгчдөд тус сургуулийн докторын хөтөлбөрт эхний улирлын сургалтын төлбөрийн 20% болон 10%-ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг олгосон.



Оюутны эрдэм шинжилгээ

Мэдээллийн Технологийн Судалгааны багаас оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа

Оюутнууд өөрсдийн бүтээсэн гар утасны аппликейшнаар Мэдээллийн Технологийн Судалгааны багаас зохион байгуулсан оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцлоо. Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хөгжүүлэх, багш, оюутны хамтарсан судалгааг дэмжих зорилготойгоор МТС-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ-VIII” 2022.11.23-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Тус хуралд 20 илтгэл хэлэлцүүлснээс:

I байр “OCR буюу зургаас текст таних нь гар утасны апп” сэдвээр Мэдээллийн систем-3 курсийн оюутан Э.Тэрбиш, Программ хангамж-3 курсийн Б.Энхзаяа, Программ хангамж-2 курсийн оюутан Б.Ширэндэв

II байр “NFC бидний хэрэглээнд, түүний ирээдүй” сэдвээр Программ хангамж-3 курсийн оюутан А.Баттөмөр

III байр “GMS dictionary вэбсайт” сэдвээр Программ хангамж-2 курсийн оюутан Б.Ширэндэв, Г.Тэмүүлэн

Тусгай байр “График өгөгдлийн сан болон уламжлалт өгөгдлийн сангийн харьцуулалт” сэдвээр Программ хангамж-3 курсийн оюутан О.Төгсбаяр

Тусгай байр “NFT буюу non - fungible token талаарх судалгаа” сэдвээр Программ хангамж-1 курсийн оюутан С.Энхбаатар нарын илтгэл шалгарлаа.



Авьяаслаг Мандахчууд

1-р курсийн оюутнуудын дунд жил бүр зохион байгуулагддаг уламжлалт “Оюутны урлагийн наадам” 2022 оны 10 сарын 08-ны өдөр “Төмөр зам Соёл урлаг, спорт”-ын төвд амжилттай болж өндөрлөлөө.

Урлагийн наадамд 11 хөтөлбөрийн оюутнууд авьяасаа сорьсноос:

I байрт 97 оноогоор Программ хангамж 1-р дамжаа

II байрт 91 оноогоор Нягтлан бодох бүртгэл аудит 1-р дамжаа

III байрт 90 оноогоор Нягтлан бодох бүртгэл банк 1-р дамжааны хамт олон тус тус шалгарлаа.

Шүүгчдийн бүрэлдэхүүнд: Соёлын тэргүүний ажилтан бүжигчин Б.Отгонзул, Соёлын тэргүүний ажилтан Хөгжимчин Н. Энхчимэг, Мэдээлэл, Технологийн тэнхимийн эрхлэгч Г.Цэнд-Аюуш, Оюутан хариуцсан ажилтан Энхжин нар ажиллалаа.



Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэнгийн нэрэмжит спортын 4 төрөлт тэмцээн амжилттай боллоо

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б. Сандагсүрэнгийн нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах уламжлалт спорт тэмцээн 2022 оны 11 сарын 3-15-ны өдөр хүртэл амжилттай болж өндөрлөлөө. Сургуулийн аварга шалгаруулах энэхүү тэмцээнийг 1997 оноос хойш уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрөлт тэмцээн болон өргөжиж, тамирчдын чансаа ч улам сайжирч байна.

2018 онд 32 баг оролцож байсан бол энэ жилийн тэмцээнд нийт 54 баг тамирчид хоёр долоо хоногийн турш өрсөлдөж өнөөдөр нэгдсэн дүнгээ гаргаж, аваргуудаа тодрууллаа. . Үүнд:

Сургуулийн аварга шалгаруулах уламжлалт спорт тэмцээнүүдийн нийлбэр дүнгээр:

I байрт: Программ Хангамж хөтөлбөрийн хамт олон шалгарч "Шилжин явах цомын эзэн"-ээр тодорлоо.

II. байрт НББ-Татвар хөтөлбөр

III байрт: Санхүүгийн менежментхөтөлбөр тус тус шалгарлаа.



Уралдаан тэмцээн

“Бизнесийн англи хэл-2022” тэмцээн зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн НББ-ийн Сургуулийн ГХТ-ээс “BUSINESS ENGLISH-2022” тэмцээнийг 2022 оны 11 сарын 15-18-ны өдрүүдэд 3-р курсын 11 ангийн оюутнуудын дунд ес дэхь жилдээ танхимаар амжилттай зохион байгууллаа.

Оюутнууд ганцаарчилсан болон багийн хэлбэрээр нийт 5 даалгавар гүйцэтгэж, тэмцээний төрөл тус бүрээр эхний 3 байрт шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа. Үүнд:

Бизнесийн захидал бичих / Ганцаарчилсан/
1 байр-Т. Амина /ИЭЗ/

2 байр-Б. Бямбасүрэн /БМ/

3 байр-Э. Эрхэмбаяр /НББАХ/

График тайлбарлах / Багийн/
1 байр-НББАудит анги

2 байр-СМ анги

3 байр-НБББанк анги

Сонсох чадвар шалгах / Ганцаарчилсан/
1 байр-М. Мөнхгэрэл /НББАХ/

2 байр-М. Амгалан /НБББ/

3 байр-Ө. Болормаа /НББТ/

Бүтээгдэхүүн идэвхжүүлэлт /Багийн/
1 байр-СМ анги
2 байр-НББМС анги
3 байр-НББАудит анги

АХА /Ганцаарчилсан/
1 байр-Б. Нарантуяа /НББА/
2 байр-Т. Цэрэндорж /НББА/
3 байр-Б. Оджаргал /НББТ/



Уралдаан тэмцээн

“Англи хэлний ур чадвар”-ын тэмцээн цахим, танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа

Мандах ИС-ийн ГХТ-ээс 2-р курсын оюутнуудын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулдаг “Англи хэлний ур чадвар”-ын тэмцээн 2022 оны 11-р сарын 15-18-ний өдрүүдэд цахим, танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээн нь оюутнуудын англи хэл сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, МАХ-1 хичээлийн мэдлэг, ур чадвараа бататгах, сорих, харилцан суралцах, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, амжилтаа бататгахад чиглэгдсэн ба тэмцээнд 13 ангийн 333 оюутан дөрвөн төрлөөр өрсөлдөж, ур чадвараа сорьсноос НББ-Банк, НББ-Англи хэл, НББ-Татвар, НББ-МС, Бизнесийн Удирдлага, Санхүүгийн менежмент, Маркетинг менежмент ангиудын нийт 12 оюутан эхний 3 байрт шалгарч, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнуулав.



Шагнал урамшуулал

ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэлд “хүндэт профессор” цол олгов

Мандах Их сургуулийн эрдмийн зөвлөлийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрээр ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэлд Монгол улсын шинжлэх ухаан болон боловсролын салбарт оруулсан хувь нэмэрийг үнэлж Мандах их сургуулийн “ХҮНДЭТ ПРОФЕССОР” цол олголоо.

Хурлын үеэр хүндэт профессорын цол олгох ёслолын ажиллагаа болж ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлд хүндэт профессорын гэрчилгээ, тэмдэгийг Мандах Их Сургуулийн захирал, профессор Г. Нанжид, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, профессор Л. Энх-Амгалан, сургалт эрхэлсэн дэд захирал, дэд профессор Ч. Төрбадрах нар гардуулж баяр хүргэлээ. Үйл ажиллагаанд ШУА-ын төлөөлөгчид болон Мандах их сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүд оролцлоо.

Академич Д.Рэгдэл нь гадаадын хэд хэдэн их сургуулийн “Хүндэт профессор” бөгөөд энэ удаа Монгол улсын их сургуулиудаас хүртэж буй анхны “Хүндэт профессор” цол юм.

Мандах их сургууль нь Шинжлэх Ухааны Академитай хамтын ажиллагаатай ажилладаг ба энэ хүрээнд эрдэм шинжилгээний судалгаа хийх, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжих, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн.



Шагнал урамшуулал

Оюутны эрдэм шинжилгээний хуралд тэргүүн байр эзлэв

Рояль Олон Улсын Их сургуулиас зохион байгуулсан “Оюунлаг залуус-Хөгжлийн ирээдүй” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурал 2022.11.11-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа. МУИС, ДХИС, ҮБХИС, ШУТИС, МУБИС, ИЗОУИС, ХИС, Мандах Их Сургууль, зэрэг 10 гаруй дотоодын Их, Дээд сургуулийн 70 орчим оюутан залуус 53 эрдэм шинжилгээний судалгааны ажил ирүүлснээс 2-р шатанд 20 илтгэлийг шалгаруулж амжилттай хэлэлцүүлсэн байна. Тус хуралд Мандах Их сургуулийн ЭЗБТ-ийн багш Ж.Гантулгын удирдсан банкны менежмент, санхүүгийн менежмент хөтөлбөрийн 3-р дамжааны оюутнууд амжилттай оролцлоо.

- Банкны менежмент 3-р дамжааны оюутан Ч.Даваацэрэн, санхүүгийн менежмент 3-р дамжааны оюутан Б.Мөнхсүвд нар “Крипто валютын ханшийг ARIMA загвар ашиглан таамаглах нь” сэдэвт илтгэлээр 2-р шатанд шалгарч илтгэл хэлэлцүүлсэн бол
- Банкны менежмент 3-р дамжааны оюутан П.Мөнхцэцэг, Ө.Сүхбат “Банкны секторын зээлийн нийлүүлэлт ба макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн хамаарлыг үнэлэх нь” сэдэвт илтгэлээр **ТЭРГҮҮН БАЙР** эзэлсэн амжилтыг тус тус үзүүллээ.



Шагнал урамшуулал

“ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ” УЛСЫН НЭЭЛТТЭЙ III ОЛИМПИАДАД “МАНДАХ” ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНУУД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ 3 БАЙР ЭЗЭЛЛЭЭ

“ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ” улсын нээлттэй III олимпиад нь 2 үе шаттай зохион байгуулагдсан бөгөөд, 2 шатыг 2022 оны 11 сарын 19-ны өдөр ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулиас Их дээд сургуулиудын дунд амжилттай зохион байгууллаа.

Тус олимпиадад ХААИС, МУИС-ХШУС, МУИС-ШУС, ДХИС-ОБС, “МАНДАХ” ИС, ТТДС, ГЛОБАЛ УДИРДАГЧ” ИС, ТДС, “ЭТҮГЭН” ИС, ШУТИС-ийн бүрэлдхүүн МТС, ЭХС, БУХС, БАС, ГУУС, МХТС нийт 14 сургуулийн 150 оюутан оролцож, оюун ухаан, эрдэм мэдлэгээ уралдууллаа.

Тус олимпиадад “МАНДАХ” ИС-ийн Бизнес удирдлагын 3-р курсын оюутан Б.Солонго 3- байранд, Санхүү менежментийн 4-р курсын оюутан Х.Цасангуа, Инженер эдийн засгийн 4-р курсын оюутан Э.Чүнсрэмъятав, Инженер эдийн засгийн 4-р курсын оюутан Б.Туяацэцэг, нар шагналт байранд шалгарлаа.



Шагнал урамшуулал

25 дах удаагийн Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны баярын өдөрт ММНБИ-с зохион байгуулдаг “Шилдэг санхүүч 2022” шалгаруулах ёслолын үйл ажиллагаанаас 4 шагналыг Мандахчууд хүртлээ

“Шилдэг санхүүч 2022” шалгаруулах ёслолын үйл ажиллагаа 25 дахь жилдээ 2022.12.09-ны өдөр зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагаанд 10 номинацаар оны шилдгүүдээ шалгаруулснаас:

- **“Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн шилдэг бүтээл”**-д Мандах ИС-ийн НББС-ийн захирал Х.Нямбаяр, мэргэшсэн нягтлан бодогч Д.Гантулга – Си Ти Ойл ХХК, Гүйцэтгэх захирал /Мандах их сургуулийн төгсөгч/
 - **“Шилдэг үнэлгээчин”** И.Гүррагчаа- Хүлэгтхүннү аудит ХХК, Гүйцэтгэх захирал / Мандах их сургуулийн төгсөгч/
- “Татварын албаны шилдэг санхүүч”** Л.Мөнхтуул- ТЕГ, Олон улсын татварын хэлтсийн дарга /Мандах их сургуулийн төгсөгч/ нар шилдгээр шалгарч манлайллаа.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалтын эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Сургалтын алба: оюутан хариуцсан ажилтан/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn